**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2026/029/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2026 оны 02 дугээр сарын 13<br>2026 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Н.Бүнчинсүрэн<br>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## НЭГ.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/35

танай__________-ны № __________ -т

БӨМБӨГӨР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЗАХИРАЛ
Ж.ГАНТӨМӨР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 1-ний өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 2.8-т "Ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид хүүхдийн хөгжлийн ахиц, багшийн ачааллыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгоно.”, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024.12.31-ний өдрийн А/279 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын

6426050100

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-албан тоот.docx

3.3-т "Энэ зааврын 3.2-т заасан хуваарийн дагуу сургалтад ашиглах материал хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, мэргэжлийн багш нарын бүлгийн ахлагчид хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий тавааc доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг цэцэрлэгийн эрхлэгч/сургуулийн захирлын тушаалаар томилон ажиллуулна" гэсэн заалтууд мөн УСНББОУС-1 Санхүүгийн толилуулга, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд хичээл, практикийн зардлыг зарцуулахдаа үйл ажиллагааг зохион байгуулах баг томилолгүйгээр 6,593.0 мянган төгрөг зарцуулсан байна.
- Сургуулийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/06 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа анги даасан багш, нийгмийн ажилтан, насан туршийн боловсролын багш нарт үндсэн цалингийн 20 хувиар бодож сар бүр бодож 5,594.3 мянган төгрөгийг илүү олгосон байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс 1,801,004.2 мянга, орон нутгийн төсвөөс 176,097.7 мянга, өөрийн орлогоос 70.0 мянга, өмнөх оны үлдэгдлээс 193,291.8 мянга нийт 2,170,463.7 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,170,463.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Халаалтын санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой 7,814.9 мянган төгрөгийн өглөгтэй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 19 зорилтын хүрээнд 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97.2 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **388,949,801.80** | **200,021,410.13** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 226,052,151.05 | 32,760,360.07 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 226,052,151.05 | 32,760,360.07 |
| **3121** | **Төгрөг** | 226,052,151.05 | 32,760,360.07 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 226,052,151.05 | 32,760,360.07 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 162,897,650.75 | 167,261,050.06 |
| **351** | **Түүхий эд материал** | 70,368,654.67 | 57,150,333.12 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 70,368,654.67 | 57,150,333.12 |
| **354** | **Хангамжийн материал** | 92,528,996.08 | 110,110,716.94 |
| 35420 | Аж ахуйн материал | 72,536,727.24 | 78,207,726.24 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19,992,268.84 | 31,902,990.70 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **950,667,209.54** | **875,955,244.50** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 950,667,209.54 | 875,955,244.50 |
| **392** | **Биет хөрөнгө** | 916,293,209.54 | 841,581,244.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 946,506,073.78 | 984,937,454.14 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -265,167,280.36 | -310,345,425.44 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 294,778,929.43 | 267,446,249.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -145,884,767.92 | -146,461,897.66 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 130,512,447.36 | 97,081,247.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -81,722,031.01 | -60,592,225.65 |
| 39217 | Ном | 37,269,838.26 | 9,515,842.75 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 34,374,000.00 | 34,374,000.00 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 34,374,000.00 | 34,374,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,339,617,011.34** | **1,075,976,654.63** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **7,814,880.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 7,814,880.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 7,814,880.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 7,814,880.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,339,617,011.34** | **1,068,161,774.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,339,617,011.34 | 1,068,161,774.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 433,663,308.00 | 433,663,308.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 433,663,308.00 | 433,663,308.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 417,527,521.92 | 147,439,677.85 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 417,527,521.92 | 418,894,914.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -271,455,236.71 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 488,426,181.42 | 487,058,788.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,339,617,011.34** | **1,075,976,654.63** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,936,186,945.00** | **2,027,828,894.86** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **66,659,745.00** | **50,725,994.86** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 66,659,745.00 | 50,725,994.86 |

| | | | |
|---|---|---|---|
| 120009 | Бусад орлого | 494,000.00 | 70,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,869,527,200.00** | **1,977,102,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,708,539,300.00 | 1,801,004,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,708,539,300.00 | 1,801,004,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 160,987,900.00 | 176,098,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 160,987,900.00 | 176,098,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,911,795,521.64** | **2,271,530,136.06** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,911,795,521.64** | **2,271,530,136.06** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,822,334,957.65 | 2,171,778,144.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,257,212,696.00 | 1,558,899,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 789,579,392.00 | 893,335,130.00 |
| 210102 | Нэмэгдэл | 397,747,154.00 | 507,227,440.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 43,275,000.00 |
| 210104 | Урамшуулал | 69,886,150.00 | 115,062,030.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,406,387.00 | 193,181,560.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 107,380,588.65 | 133,224,546.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,591,926.96 | 15,673,476.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,431,469.05 | 8,039,571.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,000,476.01 | 7,293,546.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,001,926.33 | 28,950,419.17 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 144,405,236.01 | 168,912,588.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,504,316.01 | 12,256,108.22 |
| 210302 | Түлш, халаалт | 133,725,920.00 | 156,656,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,175,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,587,300.00 | 34,863,370.55 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,497,700.00 | 7,149,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 323,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 350,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,428,300.00 | 5,533,100.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 9,661,300.00 | 21,506,820.55 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,949,550.00 | 52,339,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 337,800.00 | 784,550.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45,611,750.00 | 51,073,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 481,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,813,500.00 | 8,947,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,813,500.00 | 8,947,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,407,028.47 | 28,153,109.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 354,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 26,053,028.47 | 28,153,109.98 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 153,553,260.17 | 126,481,665.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,145,100.00 | 11,853,923.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,152,700.00 | 8,141,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 105,255,460.17 | 106,486,742.53 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 89,460,563.99 | 99,751,991.78 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 88,502,900.00 | 99,751,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 61,587,000.00 | 85,902,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,915,900.00 | 13,848,700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 957,663.99 | 991.78 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 957,663.99 | 991.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **24,391,423.36** | **-243,701,241.20** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 27,753,995.51 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 27,753,995.51 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -27,753,995.51 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **24,391,423.36** | **-271,455,236.71** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,870,021,200.00** | **1,977,172,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **494,000.00** | **70,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 494,000.00 | 70,000.00 |
| 120009 | Бусад орлого | 494,000.00 | 70,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,869,527,200.00** | **1,977,102,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,708,539,300.00 | 1,801,004,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,708,539,300.00 | 1,801,004,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 160,987,900.00 | 176,098,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 160,987,900.00 | 176,098,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,811,309,661.47** | **2,150,734,690.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,811,309,661.47** | **2,150,734,690.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,721,849,097.48** | **2,054,528,999.20** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,257,212,696.00 | 1,554,447,360.00 |
| 210101 | Үндсэн цалин | 792,818,742.00 | 868,694,931.00 |
| 210102 | Нэмэгдэл | 394,507,804.00 | 532,845,781.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 41,470,800.00 |
| 210104 | Урамшуулал | 69,886,150.00 | 111,435,848.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,406,387.00 | 197,633,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 107,380,588.05 | 134,390,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,591,926.96 | 15,810,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,431,469.58 | 7,905,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,000,476.01 | 7,905,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,001,926.40 | 31,621,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 144,730,236.01 | 161,097,708.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,780,534.01 | 12,256,108.22 |
| 210302 | Түлш, халаалт | 134,449,702.00 | 148,841,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,611,750.00 | 54,620,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45,611,750.00 | 54,620,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,300,000.00 | 15,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,300,000.00 | 15,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,407,028.47 | 28,503,109.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 354,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 26,053,028.47 | 28,503,109.98 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 76,181,000.00 | 43,227,021.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 63,603,600.00 | 34,686,021.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,577,400.00 | 8,541,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **89,460,563.99** | **96,205,691.78** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 88,502,900.00 | 96,204,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 61,587,000.00 | 82,356,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,915,900.00 | 13,848,700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 957,663.99 | 991.78 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 957,663.99 | 991.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **58,711,538.53** | **-173,561,790.98** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,151,000.00** | **19,730,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,151,000.00** | **19,730,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,151,000.00 | 19,730,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,151,000.00 | 19,730,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-10,151,000.00** | **-19,730,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 48,560,538.53 | -193,291,790.98 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 177,491,612.52 | 226,052,151.05 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 226,052,151.05 | 32,760,360.07 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 433,663,308.00 | 488,426,181.42 | 393,136,098.56 | 1,315,225,587.98 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **393,136,098.56** | 1,315,225,587.98 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 24,391,423.36 | 24,391,423.36 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **417,527,521.92** | 1,339,617,011.34 |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **417,527,521.92** | 1,339,617,011.34 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1,367,392.64 | 1,367,392.64 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **418,894,914.56** | 1,340,984,403.98 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -1,367,392.64 | 00.00 | -1,367,392.64 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -271,455,236.71 | -271,455,236.71 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **433,663,308.00** | **487,058,788.78** | **147,439,677.85** | 1,068,161,774.63 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|
| | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | зөрүү | хувь |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,825,524,400.00** | **1,801,004,200.00** | **24,520,200.00** | **98.7%** |
| Улсын төсвөөс санхүүжих | 1,825,524,400.00 | 1,801,004,200.00 | 24,520,200.00 | 98.7% |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **176,095,700.00** | **176,097,708.22** | **-2,008.22** | **100.0%** |
| Орон нутгийн төсвөөс | 176,095,700.00 | 176,097,708.22 | -2,008.22 | 100.0% |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **233,104,400.00** | **70,000.00** | **233,034,400.00** | **0.0%** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,043,900.00 | | 8,043,900.00 | 0.0% |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 70,000.00 | -70,000.00 | 0.0% |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 225,060,500.00 | 00.00 | 225,060,500.00 | 0.0% |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **2,234,724,500.00** | **1,977,171,908.22** | **257,552,591.78** | **88.5%** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | **1,803,557,100.00** | **1,752,081,160.00** | **51,475,940.00** | **97.1%** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,603,162,000.00** | **1,554,447,360.00** | **48,714,640.00** | **97.0%** |
| Үндсэн цалин | 964,644,700.00 | 868,694,931.00 | 95,949,769.00 | 90.1% |
| Нэмэгдэл | 546,745,500.00 | 532,845,781.00 | 13,899,719.00 | 97.5% |
| Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 41,470,800.00 | -41,470,800.00 | 0.0% |
| Урамшуулал | 91,771,800.00 | 111,435,848.00 | -19,664,048.00 | 121.4% |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **200,395,100.00** | **197,633,800.00** | **2,761,300.00** | **98.6%** |
| Тэтгэврийн даатгал | 136,268,700.00 | 134,390,600.00 | 1,878,100.00 | 98.6% |
| Тэтгэмжийн даатгал | 16,031,500.00 | 15,810,600.00 | 220,900.00 | 98.6% |
| ҮОМШӨ-ний даатгал | 8,015,800.00 | 7,905,800.00 | 110,000.00 | 98.6% |
| Ажилгүйдлийн даатгал | 8,015,800.00 | 7,905,800.00 | 110,000.00 | 98.6% |
| Эрүүл мэндийн даатгал | 32,063,300.00 | 31,621,000.00 | 442,300.00 | 98.6% |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **331,962,700.00** | **322,177,839.20** | **9,784,860.80** | **97.1%** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **164,095,700.00** | **161,097,708.22** | **2,997,991.78** | **98.2%** |
| Гэрэл, цахилгаан | 13,000,000.00 | 12,256,108.22 | 743,891.78 | 94.3% |
| Түлш, халаалт | 150,095,700.00 | 148,841,600.00 | 1,254,100.00 | 99.2% |
| Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 00.00 | 1,000,000.00 | 0.0% |
| **Нормативт зардал** | **57,428,700.00** | **54,620,000.00** | **2,808,700.00** | **95.1%** |
| Хоол, хүнс | 57,428,700.00 | 54,620,000.00 | 2,808,700.00 | 95.1% |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,000,000.00** | **15,000,000.00** | **0.00** | **100.0%** |
| Урсгал засвар | 15,000,000.00 | 15,000,000.00 | 0.00 | 100.0% |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **31,598,600.00** | **28,503,109.98** | **3,095,490.02** | **90.2%** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 140,000.00 | 00.00 | 140,000.00 | 0.0% |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 31,458,600.00 | 28,503,109.98 | 2,955,490.02 | 90.6% |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **63839700.00** | **62957021.00** | **882,679.00** | **98.6%** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 55,111,500.00 | 54,416,021.00 | 695,479.00 | 98.7% |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,728,200.00 | 8,541,000.00 | 187,200.00 | 97.9% |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **99204700.00** | **96204700.00** | **3,000,000.00** | **97.0%** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **99,204,700.00** | **96,204,700.00** | **3,000,000.00** | **97.0%** |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 85,356,000.00 | 82,356,000.00 | 3,000,000.00 | 96.5% |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,848,700.00 | 13,848,700.00 | 0.00 | 100.0% |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **2,234,724,500.00** | **2,170,463,699.20** | **64,260,800.80** | **97.1%** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 226,052,151.05 | 0.00 | 0.0% |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 32,760,360.07 | 0.00 | 0.0% |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.0% |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 49 | 49 | 0.00 | 100.0% |
| Удирдах ажилтан | 3 | 3 | 0.00 | 100.0% |
| Гүйцэтгэх ажилтан | 28 | 28 | 0.00 | 100.0% |
| Үйлчлэх ажилтан | 18 | 18 | 0.00 | 100.0% |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 50,093.1 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 5,594.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 44,498.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүллээ.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 5,0093.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 38,161.0 мянган төгрөгөөр Их тул Хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

**3.1 Төлбөрийн акт**

1. Сургуулийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/06 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа анги даасан багш, нийгмийн ажилтан, насан туршийн боловсролын багш нарт үндсэн цалингийн 20 хувиар бодож сар бүр бодож 5,594.3 мянган төгрөгийг илүү олгосон байна..

Энэ нь Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 1-ний өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 2.8-т "Ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид хүүхдийн хөгжлийн ахиц, багшийн ачааллыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хууль тогтоомж зөрчин олгосон 5,594.3 мянган төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлэн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**3.2 Албан шаардлага**

1. Тайлант онд хичээл, практикийн зардлыг зарцуулахдаа үйл ажиллагааг зохион байгуулах баг томилолгүйгээр 6,593.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024.12.31-ний өдрийн А/279 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 3.3-т "Энэ зааврын 3.2-т заасан хуваарийн дагуу сургалтад ашиглах материал хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, мэргэжлийн багш нарын бүлгийн ахлагчид хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий тавaас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг цэцэрлэгийн эрхлэгч/сургуулийн захирлын тушаалаар томилон ажиллуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хичээл практикийн зардлыг зарцуулахдаа журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулах баг томилон шийдвэр гаргаж зарцуулж байх албан шаардлагыг хүргүүлэв.

2. Ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг томилолгүйгээр захирлын тушаалаар тайлант онд 37,409.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан А/35/А/10/9 тушаалын 8 дах "Багш ажилтныг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухай байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг олгохдоо тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн олгож байх, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгохгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

3. Сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/69 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороо болон дотоод хяналтын даргад 2 дугаар улирлын урамшуулалд 496.7 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно."

Шийдвэрлэсэн: Ёс зүйн хорооны гишүүдэд цалингийн цалингийн зардлаас урамшуулал олгодог байдлыг таслан зогсоож Төрийн хэмнэлтийн хуулийг дагаж мөрдөх албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** **(мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд хичээл, практикийн зардлыг зарцуулахдаа үйл ажиллагааг зохион байгуулах баг томилолгүйгээр 6,593.0 мянган төгрөг зарцуулсан байна. | 1 | 6,593.0 | | | 1 | 6,593.0 | | |
| Сургуулийн захиралын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/06 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа анги даасан багш, нийгмийн ажилтан, насан туршийн боловсролын багш нарт үндсэн цалингийн 20 хувиар бодож сар бүр бодож 5,594.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 5,594.3 | 1 | 5,594.3 | | | | |
| Ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг томилолгүйгээр захирлын тушаалаар тайлант онд 37,409.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна. | 1 | 37,409.0 | | | 1 | 37,409.0 | | |
| Дүн | 4 | 50,093.0 | 1 | 5,594.3 | 3 | 44,498.7 | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/69 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороо болон дотоод хяналтын даргад 2 дугаар улирлын урамшуулалд 496.7 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна. | 1 | 496.7 | 1 | 496.7 | | |
| Дүн | 1 | 496.7 | 1 | 496.7 | | |

------------oOo-------------